



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ
СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.НЯМСАМБУУ ТАНАА

2017.03.15 № 3/464
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн санхүүгийн тайлан болон тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

070717

Зөрчилгүй санал дүгнэлт

"Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



ҮАГ

**ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ
ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” ТӨХК**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Үндэсний аудитын газар:

2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

САГ-ын дарга,
Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 26-16-63

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 26-05-12

АУДИТЫН ТАЙЛАН

Ахлах аудитор: Н.Батсайхан
Утас: 26-05-12

Веб хуудас: www.mnao.pmis.gov.mn

Монгол улс, Үндэсний аудитын газар
“Засгийн газрын IV байр”, УБ-46
Бага тойруу-6

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын дуусвар болголтын тайлан
Хавсралт 3: Аудитын гэрчилгээ
Хавсралт 4: Менежментийн захидал
Хавсралт 5: Аудит хийсэн санхүүгийн тайлан



“Интер Аудит” ХХК:

Ахлах аудитор: П.Дарамрагчаа
Утас: 31-53-18, 99-11-05-45

2017 оны 3 дугаар сар

Аудитор: Ч.Намуунбайгаль
Утас: 99-74-43-89

Е-мэйл: info@interaudit.mn
Web: www.interaudit.mn

Чингэлтэй дүүрэг, Их тойруу 15
“Ренталон” ХХК-ийн байр, өрөө 310

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Эдийн засгийн үзүүлэлтүүдийн гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Монгол улсын Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 болон “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгүүлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.6 дахь заалтын дагуу Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны 9 дүгээр сарын 01-ны өдрийн А/93 дугаар тушаалаар “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн /цаашид “Компани” гэж товчилно/ 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайлангийн /УАГ-САГ/2017/ ... /СТА-ГАК-ТӨХЭ/ аудитыг бид гүйцэтгэлээ.

Аудитыг Аудитын тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд, Аудитын олон улсын стандартын үндсэн зарчим, аудитын төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 2017 оны 3 дугаар сарын 15-ны хооронд хэрэгжүүлж ажиллав. Компанийн 2016 оны жилийн санхүүгийн тайланд хийх аудитын төлөвлөлт, дуусгавар болголт шатанд гүйцэтгэсэн ажлуудыг ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан. ЦДҮС ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС болон НББОУС, түүнд нийцүүлж гаргасан журам, заавар, компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тодорхойлсон бүртгэлийн горим, дансны бичилт, батламж мэдэгдлийг шалгуур болгон ашиглаж үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж, дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго байв.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2014 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан Компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1-д зааснаар нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 2,280,177,640 ширхэг хувьцаа гаргасан. Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хэрэгжүүлж байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөө цагт Компанийн эрх барих байгууллага болох Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ нь Компанийн Гүйцэтгэх захирлыг томилж гэрээ байгуулна. Гүйцэтгэх захирал нь Компанийн тухай хуулийн 84.4 дүгээр зүйлийн 84.4.1-д “хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх, 84.4.2-т “үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх”, 84.4.3-т “компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах” гэж заасны дагуу компанийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааг үр нөлөө бүхий удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцан ажиллаж байна.

Компани аж ахуйн үйл явдал, ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгах, санхүүгийн тайлан бэлтгэхдээ Сангийн яамнаас зохих зөвшөөрөл олгосон компьютерийн програм хангамжийг ашиглах үүрэгтэй.

Санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, СТОУС болон НББОУС-ын дагуу,

материаллаг алдаагүй, үнэн зөв, шударгаар илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Компанийн удирдлагаас бэлтгэсэн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 5-ны өдөр аудиторт ирүүлсэн ба аудитын ажлыг "Интер Аудит" ХХК-ийн ахлах аудитор, МНБ П.Дарамрагчаа, Аудитор, МНБ Ч.Намуунбайгаль, Чанарын хяналтын мэргэжилтэн О.Мягмарсүрэн, Аудиторын туслах, МНБ М.Чимэд-Очир, Аудиторын туслах Б.Анхтуяа нар гүйцэтгэв. Аудитын төгсгөлийн буюу дуусгавар болгох шатны хяналт болон тайланг "Интер Аудит" ХХК-ийн Гүйцэтгэх Захирал, Ахлах аудитор П.Дарамрагчаа, Чанарын хяналтын ажилтан О.Мягмарсүрэн нар гүйцэтгэв. Аудиторын тайланг Үндэсний аудитын газраас хянаж баталгаажуулсны дараа гэрчилгээний хамт компанийн удирдлагад толилуулах болно.

2. Байгууллагын хууль эрх зүйн орчин:

Компани нь Монгол улсын Эрчим хүчний тухай, Компанийн тухай, Иргэний тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Хөдөлмөрийн тухай хууль, татвар болон нийгмийн даатгалын тухай багц хуулиуд, бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, бусад яам агентлагаас гаргасан тогтоол, тушаал, шийдвэр, дээрх байгууллагуудаас батлан гаргасан дүрэм, журам, заавар, аргачлалыг мөрдөж байна. Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэх үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн, Аудитын болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ-ын зэрэг хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлсэн, мөн ЭХЗХ-ны 2016 оны 53 дугаар тогтоолоор "Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам"-д өөрчлөлт орсон, мөн энэ хорооны тогтоолоор дамжуулалтын үйлчилгээний төлбөр буюу тарифыг 2 удаа өөрчилж, нэг кВт.цагийн хувьсах тариф нь 0.93 төгрөг болж нэмэгдсэнээс өөрөөр тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа гол хууль, тогтоомж, журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд "Төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх, хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж төрийн өмчит болон улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны зорилтыг нийтлэг байдлаар тодорхойлжээ.

ЦДҮС ТӨХК-ийн үйл ажиллагааны зорилго нь эрчим хүч үйлдвэрлэгч ТЗЭ Компанаас эрчим хүч түгээх ТЗЭ компанид эрчим хүч дамжуулах, цахилгаан

дамжуулах шугам тоноглолын хэвийн найдвартай ажиллагааг бүрэн хангаж ажиллах явдал юм. Дулааны 6 цахилгаан станц, нэг салхин паркаас үйлдвэрлэсэн, түүнчлэн ОХУ, БНХАУ-аас импортолсон цахилгаан эрчим хүчийг Улаанбаатар хот, 16 аймаг, 230 гаруй сум, суурин газарт дамжуулж, эрчим хүч түгээх 12 аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлж байна. Нийслэл хот болон орон нутагт 5 салбартай, тэдгээр нь Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу үйл ажиллагаа явуулдаг. Салбарууд нь санхүүгийн тайлангаа СТОУС 10 "Нэгтгэсэн санхүүгийн тайлан"-ын дагуу бэлтгэж төв компанийн санхүүгийн тайланд нэгтгэдэг. Эрчим хүчний тухай хуульд 2015 оны 06 дугаар сарын 21-нд орсон нэмэлт, өөрчлөлтөөр төвийн эрчим хүчний системийн нэг худалдан авагчтай загварын арилжааны операторын болон цахилгаан эрчим хүчний импорт, экспортын үйл ажиллагааг 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс Эрчим хүчний "Диспетчерийн үндэсний төв" ТӨХК-д шилжүүлж өгсөн, компанийн бүтцийн нэгж "Болор" амралтын газрын үйл ажиллагааг 2016 оны 8 дугаар сараас зогсоосон зэрэг бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны өөрчлөлт хийгджээ.

4. Аудитын шалг уур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Компанийн санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмыг үнэлж, нягтлан бодох бүртгэлийн данс, санхүүгийн тайлангийн элементүүдээс голлох үүрэг бүхий, материаллаг дүнтэй, анхаарал татахуйц хийгээд алдаа, буруу илэрхийлэл агуулсан байх магадлалтай ажил гүйлгээ бүрийг түүврийн сорилоор шалгав.

Компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөх, тайлан бэлтгэх үйл ажиллагаанд 2007 онд Гүйцэтгэх Захирлын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэ баримт бичигт Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар", Эрчим хүчний зохицуулах хорооны 2015 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан "Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцох журам" зэрэгт орсон өөрчлөлтийг нэмж оруулжээ. Гэвч ЭХЗХ-ны 2016 оны 53 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцох журамд дахин өөрчлөлт орсон, мөн 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Сангийн сайдын 249 тоот тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар"-ын дагуу Нягтлан бодох бүртгэлийн горим, дансдын нийтлэг бичилт, жишиг жагсаалт, нэгдсэн кодчиллын дагуу Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх шаардлага бий болсон байна.

Аудитаар компанийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс гүйцэтгэх удирдлагаас бэлтгэж толилуулсан санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баримт, баталгаа олж авахын тулд голлох нөлөө бүхий данс, үзүүлэлтүүдийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын хэмжээг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлангийн нийт зардлыг /32,684,597.4 мянган төгрөг материаллаг байдлын суурь болгон авч, түүний 0.2 хувь буюу 65,369.2 мянган төгрөгөөр тогтоосон. Харин гүйцэтгэлийн үе шатанд энэ хэмжээг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлангийн нийт зардлыг /40,956,537.9 мянган төгрөг/ материаллаг байдлын суурь болгон авч, түүний 0.1 хувиар буюу 40,956.6 мянган төгрөгөөр шинэчлэн тодорхойлов.

Аудитад Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС болон холбогдох НББОУС-ын параграф, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн зүйл, заалтыг шалгуур болгон авав. Компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн програм хангамжийн үйл ажиллагааг ярилцлага асуулгын аргаар судлав. Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэхэд хэрэглэж байгаа "Ординат" ХХК-ийн боловсруулсан "Юникус" програм хангамжийн мэдээлэл боловсруулалтын үр дүн нь Монгол улсын хууль, НББОУС-д нийцүүлж боловсруулсан журам, заавар, тус компанид мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн агуулгад нийцэж байна. Мэдээллийн системийн нарийн төвөгтэй байдлын үнэлгээгээр бага эрсдэлтэй буюу мэдээлэл технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэсэн дүн гарсан тул аудитыг шууд гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-2/

Аудитын явцад Компанийн төв, Төвийн болон Хангайн бүсийн салбарын үндсэн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, бүртгэл, тайлан товчоо, санхүүгийн тайлан бэлтгэсэн бодлого, горимыг газар дээр нь хянаж шалгав. Хөрөнгө, өглөг, өмч, орлого, зардал, цалин зэрэг голлох данс үзүүлэлтийн үлдэгдэл, гүйлгээний багц бүрийн 90-100 хувийг аудитын төлөвлөсөн горимоор хамруулж шалгав. Нарийвчилсан сорилоор нийт орлогын 80 хувь, нийт зардлын 100 хувь, нийт хөрөнгийн 80 хувийг хамруулж хэрэгжүүлэв. Дээр дурдсан мэдээллүүд нь тухайн данс үзүүлэлтийн ажил гүйлгээний нийт багцын 85 хувиас доошгүй хэсгийг хамарч байна. /ТАБ-СТА-В-3/

Мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, урьдчилж төлсөн тооцоо, биет бус хөрөнгө, төлбөр, банкны богино хугацаатай зээл, урьдчилж орсон орлого, урт хугацаат өглөг, орлого, зардлын данс үзүүлэлтийн анхан шатны ба нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тооллого тооцоо бодолт, гүйлгээ ба үлдэгдлийн баталгаажуулалт, түүний дотор дансдын хүлээн зөвшөөрөлт, үнэлгээ, иж бүрэн байдал, тооцоолол, тайлагналд НББОУС, Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн тухай заавар, журмын шалгуураар аудитын хяналтыг хэрэгжүүллээ. Мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, түүний элэгдэл хорогдол, Хөрөнгө оруулалт, Их засвар, ТЗБАХ, цалин хөлс, албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл дансдын хувьд бүх анхан шатны бүртгэл, үндсэн ба дэмжих баримт, тайлан, тооцоолол ба тайлагналын үйл явц, үр дүнгийн мэдээллүүд аудитын бусад горим, сорилд шаардлагатай хэмжээгээр хамрагдав. Мөнгө, авлага, өр төлбөрийн оршин байдлыг эерэг ба сөрөг тулган баталгаажуулалтаар үнэлж, бараа материалаарх хөрөнгө, үндсэн хөрөнгийг сонголтын аргаар хэсэгчилсэн биет шалгалтын горимоор гүйцэтгэв.

Компанийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, Эрчим хүчний яам, Сангийн яам болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Эрчим хүчний зохицуулах хороо, бусад байгууллагаас гаргасан шийдвэр, удирдамжийн баримт бичгүүд, тэдгээрийн хэрэгжилтийн байдалтай танилцав. Компанийн төлөөлөн удирдах Зөвлөлийн хурлын тогтоол, протокол, Гүйцэтгэх Захирлын тушаал тэдгээрийн биелэлт хэрэгжүүлэлтийн байдлыг үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдтэй холбон шалгаж үнэлэв. Компанийн төлөвлөлт, худалдан авалт, хангамж үйлчилгээ, дотоод хяналтын системийн зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар холбогдох судалгааг хийж үнэлэв.

Аудитаар хэрэгжүүлсэн горимууд нь тухайн данс, үзүүлэлтүүдийн хувьд аудитын хангалттай, хүрэлцээтэй нотлох баримтыг олж авах зорилгод үндэслэсэн. Аудитаар компанийн хөрөнгө, өр төлбөр орлого, зарлага, хуримтлагдсан үр дүн, өмчийн данс, үндсэн үзүүлэлтүүдийн бодит байдал, үнэн шударга тайлагналд холбоо бүхий биет болон хяналтын нийт 116 сорилыг гүйцэтгэж судлан, үнэлгээ ба үр дүнг зохих ёсоор баримтжуулав. /ТАБ-СТА-В-3/

5. Дотоод хяналт:

Компанийн удирдлагаас хэрэгжүүлэх дотоод хяналтын үр нөлөөг судалж тодруулах, санхүүгийн тайланд материаллаг алдаатай илэрхийлэгдсэн эсэхийг нягтлах зорилгын үүднээс дотоод хяналтын асуулга бэлтгэн ярилцаж хариулт авсан. Дотоодын ба хөндлөнгийн хяналт шалгалтын ажлын тайлан үр дүн, үнэлгээ, дүгнэлт болон өгсөн санал зөвлөмжийн биелэлтийн байдалтай танилцав.

Компанийн дотоод хяналтын бодлого нь Засгийн газрын 2011 оны 311 ба 2012 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, “Дотоод аудитын дүрэм”-д үндэслэдэг. Техник технологи, мониторинг шинжилгээ, санхүүгийн хяналт шалгалт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан 6 ажилтан бүхий Хяналт мониторингийн хэлтэст санхүүгийн дотоод аудитор харьяалагдаж компанийн төв, салбарт нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэж байгаа байдалд дотоод хяналтын бодлого, горимыг хэрэгжүүлж ирсэн байна.

Гүйцэтгэх захирлын 2013 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар “Компанийн дотоод аудитын санхүүгийн хяналт шалгалтын журам”-ыг баталсан ба тайлант онд Болор амралтын газар, Хангайн болон Зүүн өмнөд бүсийн салбар, санхүү эдийн засгийн хэлтсийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийжээ. Шалгалтын ажлын тайланг компанийн Гүйцэтгэх Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр хугацаатай албан даалгавар өгч, биелэлтийг сар бүр гаргуулан авч ажилласан байна. Тайлант онд Эрчим хүчний яам, ТЕГ-аас компанийн санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгдээгүй, харин УНДЕГ-аас нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар шалгалт хийгджээ. Салбарын дотоод хяналтын ажлын зохион байгуулалт үйл ажиллагаатай танилцсан үр дүн, компанийн дотоод хяналтын ажлын хүрээнд хэрэгжүүлсэн аудитын

хяналт сорилын үр дүнгээр дотоод хяналтын эрсдэлийг бага гэж тооцсон ба аудитын гүйцэтгэлийн шатанд энэ үнэлгээг өөрчлөөгүй.

6. Эдийн, засгийн үзүүлэлтүүдийн гүйцэтгэл, түүний талаархи тайлбар

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 1 дүгээр сарын 28-ны 1 дүгээр тогтоол, Гүйцэтгэх Захирлын А/52 дугаар тушаалаар компанийн 2016 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн анхны төлөвлөгөөг батлуулж мөрдөж ажилласан. Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 6-ны 29 дугаар тогтоолоор энэ төлөвлөгөөг тодотгож, нийт орлогыг 39,421,201.1 мянган төгрөгөөр, нийт зардлыг 39,021,201.1 мянган төгрөгөөр, нийт ашгийг 400,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 08 дугаар тогтоол, Гүйцэтгэх Захирлын 2016 оны А52 дугаар тушаалаар баталсан компанийн 2016 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний биелэлтийг дор үзүүлэв.

№	үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 оны		Дутуу /+/, Илүү /-/
			төлөвлөгөө	гүйцэтгэл	
1	Дамжуулах цахилгаан эрчим хүч	сая кВт.цаг	4,789.3	4,722.4	66,9
2	Дамжуулалтыг алдагдал	хувь	3,33	3,32	-0,02
3	Нийт орлого	сая төг	39,421.2	41,080.4	-1,659.2
	үүнээс: дамжуулалтын үйлчилгээний төлбөр	сая төг	38,201.7	38,147.6	54.1
	үндсэн бус үйл ажиллагааны орлого	сая төг	1,219.5	2,932.8	-1,713.3
4	Нийт зардал	сая төг	39,021.2	40,983.5	-1,962.3
5	Үйл ажиллагааны нийт ашиг /алдагдал/	сая төг	400	96,9	303,1
6	Орлогын албан татвар	сая төг	0	320,5	-320,5
7	Татвар төлсний дараах ашиг /алдагдал/	сая төг	400	-223,6	-623,6
8	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	төг	1	1	-
9	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт	сая төг	6,700.2	6,384.0	316,2
10	Нийт авлага	сая төг	2,682.4	3,306.6	-624,2
	үүнээс: богино хугацаат авлага	сая төг	1,285.1	1,988.3	-703,2
11	Нийт өглөг, өр төлбөр	сая төг	24,678.1	21,865.9	2,812,2
	үүнээс: богино хугацаат өглөг, өр төлбөр	сая төг	2,887.5	2,580.2	307,3
12	Байгаль орчин инновацийн асуудлыг шийдсэн байдал	тоо	2	2	-
13	Нийт ажилтны тоо	хүн	1,125	1,086	39

ЭХЗХ-ны хорооны 2016 оны 5 дугаар тогтоолоор нэг кВт.цагийн үйлчилгээний төлбөр буюу хувьсах тарифыг 0,74 төгрөгөөр, үйлчилгээний тогтмол тарифыг сард 2,649,987.2 мянган төгрөгөөр, дараа нь 2016 оны 194 дүгээр тогтоолоор нэг кВт.цагийн үйлчилгээний төлбөр буюу хувьсах тарифыг 0,93 төгрөгөөр, үйлчилгээний тогтмол тарифыг сард 3,988,692.8 мянган төгрөгөөр шинэчлэн мөрдүүлэхээр батласан байна.

Тайлант онд дамжуулах үйлчилгээний орлогоор 38,147,620.3 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлогоор 2,932,763.1 мянган төгрөг, нийт 41,080,383.4 мянган төгрөгийг хүлээн зөвшөөрсөн нь төлөвлөсөн хэмжээнээс 1,659,182.3 мянган төгрөгөөр илүү байна. Нийт зардлыг 39,021,201.1 мянган төгрөгөөр төлөвлөсөн, гүйцэтгэл 40,983,507.8 мянган төгрөг байгаа нь төлөвлөсөн хэмжээнээс 1,962,306.7 мянган төгрөг илүү зарцуулсан байна.

Үйл ажиллагааны үр дүнгээр 400,000.0 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллагаар төлөвлөснөөс 96,875.6 мянган төгрөгийн ашигтай гарч, орлогын албан татвар ногдуулсан 320,490.7 мянган төгрөгийг хассанаар, татварын дараах алдагдал 223,615.1 мянган төгрөг байна.

Өмнөх оноос богино хугацаатай авлага 703,263.4 мянган төгрөгөөр өсөж, богино хугацаат өр төлбөр 307,313.9 мянган төгрөгөөр буурсан байна. Авлага, өглөгийн хэмжээ өөрчлөгдөхөд нэг худалдан авагчтай загварын нэгжээс авах авлага 763,273.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн, ОХУ-аас цахилгаан эрчим хүч хүлээн авсан импортын өглөг 1,288.397.3 мянган төгрөгийг бүрэн төлж барагдуулсан зэрэг нь голлох нөлөө үзүүлжээ.

Санхүүгийн тайлан, тодруулгыг Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан маягт аргачлалын дагуу бэлтгэсэн ба ЭХЗХ-ноос батлан гаргасан хүснэгт маягтуудыг хавсаргасан байна. Тайлант оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлт, санхүүгийн тайлангийн үр дүнд шинжилгээ хийн, үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээр голлох зорилтуудыг тодорхойлсон байна.

7. Шилэн дансны мэдээлэл

Компанийн 2016 оны зорилтот түвшин, бизнесийн төлөвлөгөөнд тусгагдсан мөнгөн урсгал, орлого, зардал, удирдлагын шийдвэр, санхүүжилт, тендер шалгаруулалт, худалдан авалт, тохиолдсон голлох үйл явдал, онцлог ажил гүйлгээний талаарх мэдээллийг <http://www.shilendans.gov.mn/org/5228> сайтад оруулж олон нийтэд толилуулж байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг түүвэрлэн шалгаж үзэхэд мэдээллийг оруулаагүй, дутуу шивсэн, давхардуулж шивсэн зэрэг тохиолдлууд илэрч байна. Жишээ нь,

- Аваарын нөөцөд болон их засварын ажилд утас АС120 нийлүүлэх ЦДҮС-2016/АН-03 дугаартай тендерийн ажлыг гэрээг "Номин Эрчим" ХХК-тай байгуулсан, гэрээ дүгнэсэн актын дүгнэлт хэсэгт "Голомт Эрвэн" ХХК-ийн нэрээр бичиж шилэн дансанд шивээгүй,
- Багануур дэд станцын /ЗӨБС/ барилгын их засварын ЦДҮС-2016/ХА-21 тоот гэрээтэй 50,176.3 мянган төгрөгийн ажлыг шилэн дансанд 9 дүгээр сард 30,523.9 мянган төгрөгийг шивж оруулсан бөгөөд 8 сард олгогдсон урьдчилгаа болох 16,224.6 мянган төгрөгийг шивж оруулаагүй, Инжин Илч ХХК-аас галын тэсэрдэг хор худалдан авч шилэн дансанд 3, 4 сард тус бүр 14,829.1 мянган төгрөгөөр буюу гэрээний дүнгээр давтан шивсэн бөгөөд баталгааны төлбөр болох 5%-ийг хассан дүнгээр 5 сард 14,087,645 төгрөгөөр дахин шивсэн,

- Улаанбаатар дэд станцын төмөр хашааг бетон хашаагаар солих 95,500.0 мянган төгрөгийн ажлын төлбөрийг шилэн дансанд 52,525.0 мянган төгрөгөөр шивсэн ба зөрүү болох 42,975.0 мянган төгрөгийг шивээгүй зэргийг аудитын асуудлын бүртгэлд нотлох баримтаар авагджээ.

Шилэн дансанд мэдээлэх үүргийг хуулийн 7.1.3-т зааснаар төлбөрийн даалгаварт 1,2 дугаар гарын үсэг зурсан албан тушаалтан хариуцах ба шилэн дансны тухай хуулийн мэдлэг, туршлага бүхий нэг ажилтанд хариуцуулах шаардлагатай гэж зөвлөмж өгснийг компанийн удирдлага зөвшөөрч хүлээж авсан.

Шилэн дансны цэсд компанийн үйл ажиллагааны талаар сонирхсон этгээдийн асуулт, тодруулгад хариу өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулахын хамт, компанийн үйл ажиллагаа, аж ахуй, санхүүгийн онцлог үйл явдал, ажил гүйлгээний мэдээллийг тухай бүр шинэчлэх, төр олон нийтийн болон дотоодын хяналт шалгалтын тайлан дүгнэлт, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг мэдээлэх ажлыг тасралтгүй зохион байгуулах хэрэгтэй.

8. Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар

┆

Аудит гүйцэтгэх төлөвлөгөөний дагуу 14 төрлийн эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлийн хүрээнд данс, элемент бүрээр нийт 26 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Үр дагаврыг зөв тодорхойлж чадвал: Арилжааны банкны хуулгын гүйлгээнээс зөрүүтэй харилцахын тайлан бэлтгэсэн, арилжааны банкинд хугацаатай хадгалуулсан том дүнтэй мөнгөний хүүг дутуу тооцож авсан, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй объект болон програм хангамжийг дуусаагүй барилга дансанд хөрөнгийн ангиллын зөрчилтэй бүртгэсэн, НХАЗ-ын үйл ажиллагаатай холбоотой урьдчилж орсон орлогыг дамжуулалтын орлогоор хүлээн зөвшөөрөөгүй 2 жил болж байгаа, зардалд хуваарилж бүртгээгүй, төлөвлөгөөнд тусгагдаагүй шилжүүлгийн дүнгээр хуримтлагдсан ашгийг бууруулсан бичилт хийсэн, ТУЗ-ийн шийдвэрээр компанийн удирдлагын 7 хүнд 2015 оны жилийн үр дүнгийн урамшууллаар 23,000.0 сая төгрөгийг олгосон, тэднээс 3 хүн нь 2015 оны 10 дугаар сараас ажиллаж эхэлсэн удирдлагын багийн гишүүд учраас жилийн биш улирлын үр дүнгээр урамшуулал тооцож авах байсан. Тухайн шагнал, урамшууллыг зардалд хуваарилж бүртгээгүй, нийгмийн даатгалын шимтгэлийн суутгалгүйгээр хуримтлагдсан ашиг, алдагдлын дансыг бууруулж олгох шийдвэрийг компанийн ТУЗ гаргасан, ажилтнуудад олгосон ажлын хөлсийг цалингийн нэгдсэн хүснэгтэд бүрэн нэгтгэж оруулахгүйгээр зөвхөн ХАОАТ-ыг суутган, НДШ-ийг орхигдуулсан, шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалттай биш, компанид ажилладаггүй хүнд Яамны удирдлагын шийдвэрээр байр олгосон, тендер зарлах, шалгаруулах үйл ажиллагаанд холбогдох хууль, журмыг зөрчсөн, худалдан авалтын төлөвлөгөөнд аваарын нөөц бэлтгэх дүнг задаргаагүй том дүнгээр тусгаж, энэ байдлаар биелэлтийг гаргасан, Ерөнхий журналын гүйлгээг харьцсан байгууллага, гүйлгээний утгыг орхигдуулж шивж байгаа нь Ерөнхий нягтлан бодогч, дотоод хяналтын аудитор болон шалгалт хийж байгаа бусад хүмүүст хиймэл бэрхшээл учруулж байгаа зэрэг зөрчил, алдаа сул талыг илрүүлж, гарч болох үр дагаварыг үнэлж, илэрсэн алдаа, зөрчлүүдийг залруулах, арилгах зөвлөмжийг менежментийн захидлаар өгөв. Эдгээр алдаа, зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба

үүрэг, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

9. Го л. онцлог гүйлгээний талаарх тайлбар :

“ЦДҮС” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага, өглөг, үндсэн хөрөнгө, бараа материал, цалин хөлсний тооцоо, түрээсийн орлого зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгав. /ТАБ-СТА-В-3/

Компанийн 2016 оны санхүүгийн тайланд тусгагдсан онцгой үйл явдал, санхүүгийн тайлагналд нөлөөлөхүйц хэмжээний томоохон дүнтэй хийгээд аудиторын анхааралд өртсөн онцлог, том дүнтэй ажил гүйлгээ бүрийг эрэмбэлэн шүүх аргаар судлав. Ийм ажил гүйлгээний хувьд анхан шатны баримтын бүрдэл, хөрөнгө, эх үүсвэрийн дансад гарсан өөрчлөлт, хөдөлгөөн, аж ахуйн үйл явдал, ажил гүйлгээг тохирох батламж мэдэгдлийн шалгуураар авч үнэлсэн болно.

1. ТӨХ-ны 2015 оны 4 дүгээр сарын 9-ний 3/963 тоот албан бичгээр Улаанбаатар салбарын Хөшигт дэд станц, Туул дэд станц болон Хайлаастын дэд станцын 18,372,838.9 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмжийг хүлээн авах үүрэг өгсөн. Үүнээс 2016 онд Хөшигт дэд станцын барилга, объект ашиглалтад орж 9,770,392.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан. Энэ дэд станцад 2014 онд 1,894,180.1 мянган төгрөгийн, 2015 онд 7,876,212.7 мянган төгрөгийн, 3 жилийн дүнгээр нийт 19,540,785.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан байна.

2. 2015 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хангайн бүсийн салбарт 14,842,979.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, Улаанбаатар салбарт 8,400,867.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээж авсан, нийт дүнгээр 23,243.846.9 мянган төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайланд хойшлогдсон орлогоор бүртгэж, 2016 онд 713,462.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулан дүнг үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалд оруулж тооцсон байна.

3. Дархан хотын 110/6 кВ-ын Давхар дэд станцын хаалттай хуваарилах байгууламжийг шинэчлэх барилга угсралтын дутуу ажлыг гүйцээсэн ажлын гүйцэтгэлээр улсын төсвөөс 134,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан, одоо хаалттай хуваарилах байгууламжийг шинэчлэхэд 125,459.5 мянган төгрөг, дэд станцын өргөтгөлд 103,003.3 мянган төгрөг, нийт 228,462.7 мянган төгрөгийн барилга угсралтын ажлын санхүүжилтийг 2017 онд улсын төсвөөс авах авлагаар бүртгэсэн байна. Үүнээс өөрөөр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон, бусад аж ахуйн нэгж, байгууллагаас шилжүүлэн хүлээн авсан том дүнтэй хөрөнгийн орлого гараагүй. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулж байгаа болон ашиглалтанд хүлээн авсан гүйцэтгэл, үр дүнгийн талаар компанийн Гүйцэтгэх удирдлага Эрчим хүчний яам, Сангийн яам, ТӨБЗГ-т тухай бүр танилцуулж, санхүүжилтийн болон гүйцэтгэлийн зөрүү гарсан бол зохих шийдвэрийг тухай бүр гаргуулж ажиллах хэрэгтэй.

10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн тал аар :

Компанийн анхан шатны ба нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан бэлтгэж байгаа байдлыг аудитын зорилгоор, хууль эрх зүйн баримт бичгийн шаардлагад нийцүүлэн нягталж шалгах явцад илрүүлсэн алдаа, зөрчил, сул тал тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаар дор тэмдэглэв. Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн данс, элемент бүрээр хийгдсэн түүврийн сорилоос баримт, ажил гүйлгээг хянасан үр дүн, нотлох баримт, алдаа зөрчлийн давтамж, ахиуц нотлох чадамжийг харгалзан санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө, ач холбогдлоор нь эрэмбэлж аудитаар илрүүлсэн гол алдаа, зөрчлийг төлөөлөл байдлаар сонгон авсан болно. Үүнд:

1. 2016 оны компанийн ТУЗ-ийн баталсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод төвшингийн төлөвлөгөөнөөс үндсэн ба нэмэгдэл цалин 968,651.2 мянган төгрөгөөр, байгууллагаас төлөх ЭМД, НДШ 130,537.9 мянган төгрөгөөр, урсгал засварын зардал 42,042.3 мянган төгрөгөөр, тэтгэмжийн зардал 46,251.1 мянган төгрөгөөр, гадны үйлчилгээний хөлс 30,531.1 мянган төгрөгөөр, харуул хамгаалалтын зардал 41,095.5 мянган төгрөгөөр, зохицуулалтын үйлчилгээний хөлс 34,900.0 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлж зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод төвшингийн төлөвлөгөөг цаашид хатуу мөрдөж, батлагдсан зардлын лимитийг барьж ажиллах зөвлөмж өгөв.

2. Худалдан авалтын төлөвлөгөөнд бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн үнийн судалгааг муу хийснээр цахилгаан үүсгүүрийн дизель генератор /АДГУ-ҮОВ-КВ/ нийлүүлэх ЦДҮС-2016/ХА-18 дугаартай тендерийн дагуу худалдан авалтын саналыг 3 компаниас авсан боловч шаардлага хангахгүй гэх үндэслэлээр бүгдээс нь татгалзсан боловч эхний шалгаруулалтаас хасагдсан Глим ХХК-тай шууд худалдан авалтын гэрээ байгуулсан зэрэг зөрчил гарсан байна. Мөн металлын гадаргуугийн будаг нийлүүлэх ЦДҮС-2016/АН-Х06 гэрээт ажил гүйцэтгэхээр "Хонка лог хоум" ХХК болон "Нью фунт" ХХК-аас үнийн санал ирүүлсэн. Нью фунт ХХК-аас ирүүлсэн үнийн санал $/685\text{л} \times 12.8 = 8,747.4$ мянган төгрөг (НӨАТ ороогүй дүн)/ үнийн саналаас татгалзсан мөртөө шууд гэрээгээр "Голден трейд" ХХК-иас $/685\text{л} \times 25.0 = 17,125.0$ мянган төгрөг/-өөр буюу 8,377.6 мянган төгрөгөөр нэг үйлдвэрийн адил будгийг илүү үнээр худалдаж авсан байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын ажиллагаанд компанийн удирдлага, дотоод хяналтын аудитор зохих хяналт тавьж, ТБОНӨХБАҮХАТ хуулийн шаардлагыг хангаж, тендер зарлах үнийн хязгаарт хүрээгүй бараа, ажил үйлчилгээний худалдан авалтанд Сангийн сайдын 2013 оны 125 тоот тушаалаар баталсан үнийн санал авах баримт бичгийг ашиглах зөвлөмж өгөв.

3. 2016 оны 2 дугаар сарын 24-нд ЦДҮС ТӨХК-ийн Голомт банкны 8115006032 тоот тэг үлдэгдэлтэй байсан Импортын дансанд Төрийн банкны Импортын 136,729.7 мянган төгрөг, Капитал-импортын данснаас 563.2 мянган төгрөг, Хаан банкны

импортын данснаас 893.7 мянган төгрөг, нийт дүнгээр 138,186.6 мянган төгрөгийг банк хоорондын шилжүүлгээр татаж байршуулсан, оны эцэст харилцахын үлдэгдэлд төлсөн хүүгийн орлогоор нэмэгдэж 142,403.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй энэ дансандаа байршилтай хэвээр байна. 2016 оны 3 дугаар сарын 31-нээр ДҮТ ХХК-аас ирүүлсэн албан бичгээр 2015 оны жилийн эцэст хоорондын тооцоогоор баталгаажсан 726,967.2 мянган төгрөгийн импортын тооцооноос үүссэн авлагыг нэхэмжилсэн албан бичиг ирсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Баримт, гүйлгээг үндэслэн аудитор "ДҮТ" ТӨХК-ийн НХАЗ-ын импортын мөнгийг шилжүүлээгүй байна гэсэн ойлголттой байсан боловч ЭХЗХ-ны хурлын протоколоор авлага, өглөгийг хооронд нь суутган хаах зөвшөөрөл өгсөн, журналын бичилт зэргийг үндэслэн асуудлыг дахин хөндөж авч үзээгүй боловч дамжуулахын болон НХАЗ-ын импортын тусгай зориулалтын дансдын хооронд хийгдсэн гүйлгээ журмын зөрчилтэйг компанийн Ерөнхий нягтлан бодогчид анхааруулсан болно.

4. Харилцахын тайлангийн эхний болон эцсийн үлдэгдэл банкны хуулгын дүнтэй тохирч байгаа боловч, ДТ, КТ-гүйлгээний дүн 41,421.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байгааг шалгаж үзэхэд 12 дугаар сарын 26-ны өдөр Мон Энержи корпорацид шилжүүлсэн мөнгөний дүнгээр зөрүүтэй байна. Шалтгаан нь банкны 12 дугаар сарын 27-ны шилжүүлэг эргэж орж ирснийг дахин шилжүүлж ДТ, КТ гүйлгээний 2 талыг энэ дүнгээр цэвэрлэсэн.

Шийдвэрлэсэн нь: Тайланг арилжааны банкны хуулгын дүнгээр боловсруулаагүй нөхцөлд банкны гүйлгээний тулган баталгаажуулалтын дүн буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй талаар менежментийн захидлаар зөвлөв.

5. Харилцахын тайлангийн КТ гүйлгээний дүн арилжааны банкны хуулгын дүнгээс 126.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байгааг шалгахад шалгахад байгууллагын нэр зөрүүтэй шалтгаанаар гүйлгээнд оруулаагүй. Мөн ДТ гүйлгээ 100 төгрөгөөр зөрүүтэй байсан нь 2016 оны 12-р сарын 27-ны өдөр 12-р сарын 22-ны өдрийн 650.6 мянган төгрөгийн цалингийн гүйлгээний шимтгэл 100 төгрөгийг нөхөн авсныг харилцахын тайланд тусгаагүй зэргээс энэ зөрүү гарчээ.

Шийдвэрлэсэн нь: Банкны тохируулгын тайланг тайлант хугацаа бүрийн эцэст хийж хэвших, гүйлгээ үлдэгдлийг баталгаажуулж байхыг менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

6. Тайлант оны 12 сард НӨАТ төлөгч компаниуд болох "Фармед Ресурс" ХХК-аас 1,155.0 мянган төгрөгийн, "Эм Эн Жи Би" ХХК-аас 1.0 сая төгрөгийн Эм, эмнэлгийн хэрэгслүүдийг худалдан авсан байна. Хангамжийн материал дансанд уг материалуудыг НӨАТ-тэй дүнгээр орлогод бүртгэсэн, НӨАТ-ын буцаалтыг хийж НӨАТ-ын тайланд тайлагнасан.

Шийдвэрлэсэн нь: Материалын өртөг буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй учраас НӨАТ-ын тайлангийн зөрүүтэй илэрхийллийг залруулах зөвлөмжийг менежментийн захидлаар өгөв.

11. Материаллаг бус залруулагдаагүй алдаа, сул талын талаарх тайлбар :

Дээр дурьдсан алдаа, зөрчлийг арилгах талаар өгсөн аудиторын зөвлөмжийг "ЦДҮС" ТӨХК-ийн СЭЗХ-ийн дарга, Ерөнхий нягтлан бодогч нар хүлээн зөвшөөрч байгаа тул аудитын залруулгыг зориудаар хийх шаардлагагүй гэж үзэв. "ЦДҮС" ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн дүн, илэрхийллийг аудитын залруулгаар өөрчлөх материаллаг хэмжээний алдаа сул тал гараагүй. Аудиторуудын анхааралд өртсөн материаллаг бус хэмжээтэй алдаа ба сул талуудыг асуудлын бүртгэлд авч, тоо хэмжээ ба үнийн дүнг нэгтгэн, аудитын горим сорилуудаар хянаж шалгасны эцэст санхүүгийн тайлангийн илэрхийллүүдэд үзүүлэх үр нөлөөгүй гэж дүгнэж байна.

1. Харин хууль хяналтын зохих байгууллагын шалгагдаад зохих шийдвэр гартал "Говийн тэнгэр" ХХК-ийн өмчлөлд байж 1987 онд ашиглалтанд орж конторын зориулалтаар 300,000.0 мянган төгрөгийн худалдан авсан барилгын үнэ цэнийг бууруулж бүртгэх, уг объектод хийгдсэн 371,584.5 мянган төгрөгийн их засварын ажлыг капиталжуулахдаа дээрх объектоос салган бүртгэх талаар өгсөн зөвлөмж залруулагдаагүй байна.

2. Мөн Капитал банктai жилийн 11 хувь, сарын 0.92 хувь, гэрээнд заасан хадгаламжийн хугацаанаас хойш сунгагдахгүй, хугацаатай мөнгөн 4 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 15 хооронд 6 сарын хугацаатай хадгаламжийн гэрээ байгуулж байршуулсан. Энэ мөнгөний 10 дугаар сарын 14-нөөс 12 дугаар сарын 23-ны хоорондох хугацааны 18,036.5 мянган төгрөгийн хадгаламжийн хүүг тайлант онд багтаан тооцуулж аваагүй байна.

12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

2016 оны тендерийн сонгон шалгаруулалтаар "Меса Инженеринг" ХХК-аас ЗИЛ 131 автомашин дээр суурилсан 2 ширхэг 26м сунадаг авто өргүүрийг худалдан авч Төвийн болон Багануур зүүн өмнөд бүсийн салбарт тус тус хуваарилсан байна. Бид Төвийн бүсийн салбар дээр ажиллах үед 1991 онд үйлдвэрлэгдсэнээс хойш 25 жил болж элэгдэл тооцох хугацаа дууссан Зил131 машин дээр суурилагдсан авто өргүүрийн нээлттэй тендер шалгаруулалтын баримт, материалыг авч танилцав. 2016 оны 5 дугаар сарын 30-ны өдөр хийгдсэн худалдан авалтын гэрээний дагуу нийлүүлэгдсэн 2 авто өргүүрийн нэгийг 8 сая төгрөгөөр үнэлж гаальд мэдүүлсэн, эдгээр авто өргүүрийн, ОХУ-ын манай оронтой хил залгаа муж, хотуудын байршлаар зарын сайтуудаар орж зах зээлийн үнийн судалгаа хийж үзэхэд 1991 оны энэ төрлийн авто өргүүрийн үнэ 450 орчим мянган рубль буюу энэ үеийн ханшаар төгрөгт шилжүүлэн тооцоход ойролцоогоор 11-12 сая төгрөг орчим худалдан авах боломжтой, үүн дээр гаалийн татвар, НӨАТ, хилийн транзит болон дотоод тээврийн зардал, банкны зээлийн хүү зэрэг гарч болох томоохон зардлыг багтаан ойролцоогоор тооцож үзэхэд нэг авто өргүүр 20,000.0 мянган төгрөгөөс хол хэтрэхгүй тооцоо гарч байгаа юм. Бараа ажил, үйлчилгээ худалдан авалтын 2016 оны 2 дугаар сарын 25-нд батлагдсан төлөвлөгөөнд 2 авто өргүүрийн худалдан авах үнийг 190,000.0 мянган төгрөгөөр (нэг авто өргүүрийн үнэ 95,000.0 мянган төгрөг) анх тусгаж байгаад 2016 оны 10 дугаар сарын 10-ны тодотгосон төлөвлөгөөнд энэ 2 авто өргүүрийг худалдан

авах үнийг 185,000.0 мянган төгрөг (нэг авто өргүүрийн үнийг 92.500. мянган төгрөг) болгон бууруулсан байна. Энэ асуудлыг эрх бүхий байгууллага нягталж шалгах шаардлагатай.

13. Дараагийн аудитаар авч үзэх ас үүдлүүд :

1. 2007 оны оноос хойш компанийн санхүүгийн тайлан /СТ-1/-д тусгагдаж ирсэн, татварын албаар баталгаажигдаагүй 155,185.0 мянган төгрөгийн хойшлогдсон татварын өглөгийг татварын зардал данснаас хааж бууруулан бичсэн байна. 2007 оны оноос хойш компанийн санхүүгийн тайлан /СТ-1/-д өөрчлөлтгүйгээр тусгагдаж ирсэн, хөөн хэлэлцэх хугацаа дууссан, татварын албаар баталгаажигдаагүй 155,185.0 мянган төгрөгийн хойшлогдсон татварын өглөгийг тайлант жилийн ажил, гүйлгээний дүнд нөлөөлүүлэхгүйгээр ТУЗ-ийн зохих шийдвэртэйгээр өмнөх үеүдийн хуримтлагдсан ашиг, алдагдлын данс руу хааж бичих боломжийг ашиглаж болохоор байна.
2. Хууль хяналтын зохих байгууллагаар шалгагдаад зохих шийдвэр гарах үед "Говийн тэнгэр" ХХК-ийн өмчлөлд байж 1987 онд ашиглалтанд орж конторын зориулалтаар 300,000.0 мянган төгрөгийн худалдан авсан барилгын үнэ цэнийг бууруулж бүртгэх, уг объектод хийгдсэн 371,584.5 мянган төгрөгийн их засварын ажлыг капиталжуулахдаа дээрх объектоос салган бүртгэсэн байдлыг хянаж үзэх,

14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл :

Энэ тайлангийн 10 дугаар зүйлд дурьдсан болон аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорилоор илрүүлж 3,480,501.3 мянган төгрөгийн материаллаг бус алдаа, зөрчил буруу илэрхийллийг аудитын зөрчлийн хүснэгтэд нэгтгэн харуулав.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтэд материаллаг нөлөө үзүүлэхгүй бүртгэлийн бичилт, тооцооллын сөрөг үр дагавар, тэдгээрийг залруулах талаар данс тооцоо хариуцсан нягтлан бодогч, Ахлах болон Ерөнхий нягтлан бодогч, СЭЗХ-ийн дарга нарт тайлбарлан зөвшилцөж, холбогдох зөвлөмж өгч энэхүү баталгаажуулалтыг хийсэн болно.

15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх аудитаар үйлчлүүлэгчид менежментийн захидлаар өгсөн зөвлөмжийн биелэлт дараах байдалтай байна.

1. Бараа, ажил үйлчилгээ худалдан авалтын талаар:

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн ерөнхий, санхүүгийн, техникийн болон туршлагыг тус хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр хянан үзэж магадлана" гэж заасны дагуу тендерийн материалын мэдээллийг нягталж, шалгах, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу Худалдан авах ажиллагаанд ил тод,

өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж ажиллах зөвлөмжийг тодорхой хэмжээнд хэрэгжүүлсэн.

2. Ажил гүйлгээг үндэслэх, нотлох баримтын тухай:

Хувь хүнээс худалдан авалт хийхдээ татварын албанаас зөвшөөрөгдсөн тэмдэгтэй баримт болон олгосон дүнгээр “татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр”-т тэмдэглэл хийн, хувилж авах ба ТТ-12(2) маягтаар татварын албанд мэдээлэх үүргээ хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлж байна.

3. Авлага, өглөгийн үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулах

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж авлага, өр төлбөрийн үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулж байх зөвлөмжийг хэрэгжүүлж байна.

16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Компанийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайлан, тэдгээрийн илчлэл тодруулгад толилуулсан үлдэгдэл, гүйлгээнүүд Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, тэдгээрт нийцүүлэн боловсруулж Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй илэрхийлэгдсэн байна.

“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ” ТӨХК

2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ :

Асуудал 1: 2016 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод төвшингийн төлөвлөгөөнөөс хэтэрсэн зардлыг хянаж ажиллах

Асуудал 2: ТБОНӨХБАҮХАТХ-ын болон Худалдан авалтын үйл ажиллагааны журмыг зөрчихгүй байх

Асуудал 3: Бараа материалын худалдан авалт, НӨАТ-ын тооцоолол, бүртгэлийн талаар

Асуудал 4: Бараа ажил үйлчилгээний худалдан авалтын төлөвлөгөөг мөрдөж ажиллахгүй байна.

Асуудал 5: Гүйлгээний дэмжих, нотлох баримт дээр ойлгомжтой тайлбар, тэмдэглэл бичиж хэвших

Асуудал 6: Шилэн дансны талаар

Асуудал 7: Ажил гүйлгээ бүрийг цаг хугацаанд бүртгэлд тусгаж байх

Асуудал 8: Харилцахын тайланг арилжааны банкны хуулгын гүйлгээ, үлдэгдлийн дүнтэй зөрүүгүй бэлтгэж, санхүүгийн тайланд гүйлгээ, үлдэгдлийн баталгаажуулалт хийж хавсаргаж байх

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар, “Интер Аудит” ХХК аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг ЦДҮС ТӨХК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх, замаар хяналтыг сайжруулах зөвлөмж бэлтгэв.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаар бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний НББ, санхүүгийн тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бэлтгэсэн бөгөөд энэхүү зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай байгууллагын үүрэг хариуцлага юм.

“ИНТЕР АУДИТ” ХХК

Асуудал 1: 2016 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод төвшингийн төлөвлөгөөнөөс хэтэрсэн зардлыг хянаж ажиллах

Тэргүүлэх ач холбогдол №1

А. Ажиглалт:

2016 оны батлагдсан төлөвлөгөөнөөс үндсэн ба нэмэгдэл цалин 968,651.2 мянган төгрөгөөр, байгууллагаас төлөх ЭМД, НДШ 130,537.9 мянган төгрөгөөр, урсгал засварын зардал 42,042.3 мянган төгрөгөөр, тэтгэмжийн зардал 46,251.1 мянган төгрөгөөр, гадны үйлчилгээний хөлс 30,531.1 мянган төгрөгөөр, харуул хамгаалалтын зардал 41,095.5 мянган төгрөгөөр, зохицуулалтын үйлчилгээний хөлс 34,900.0 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлж зарцуулсан байна.

В.Эрсдэл:

Компанийн ТУЗ, ЭХЗХ, ЭХЯ, ТӨБЗГ-аар хянаж батлагдсан зорилтот төвшний үзүүлэлтээр батлагдсан үйл ажиллагааны зардлыг төлөвлөгөөнөөс хэтрүүлж зарцуулах нь нэг талаас компанийн санхүүгийн сахилга бат хангалтгүй, нөгөө талаас компанийн эрх барих дээд байгууллагын шийдвэрийг зөрчих, компанийн орлого, үр дүнгийн үзүүлэлтийг бууруулах эрсдэлтэй.

С.Зөвлөмж:

Цаашид ТУЗ-ийн шийдвэрээр батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот төвшингийн үзүүлэлт, лимитэд багтаан үйл ажиллагааны зардал, санхүүжүүлтийг хэрэгжүүлэх талаар компанийн Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч нар анхаарч ажиллах

Д.Үйлчлүүлэгчийн хариу:

2016 оны төлөвлөгөөгөөр тогтоосон зардлын лимитээс хэтэрсэн цалин, урсгал засвар, харуул хамгаалалт, гадны үйлчилгээний хөлс зэрэг зардал нь Монгол улсад зохион байгуулагдсан АСЕМ-ийн дээд хэмжээний чуулга уулзалттай холбоотойгоор Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврын дагуу хийгдсэн ажлуудтай холбоотойгоор гарсан зардлууд юм. Эрчим хүчний зохицуулах хорооны 2016 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг батлах тухай” 49 дүгээр тогтоолын дагуу төлбөрийг төлсөн. Энэ талаар цаашид анхаарч ажиллана.

Асуудал 2: ТБОНӨХБАҮХАТХ-ын болон худалдан авалтын үйл ажиллагааны журмыг зөрчихгүй байх

Тэргүүлэх ач холбогдол №2

А. Ажиглалт:

Компанийн худалдан авах ажиллагаа, тендер шалгаруулалтын үйл ажиллагааг шалгахад дараах зөрчлүүд илэрч байна. Үүнд:

- Эзэмшил нэгтэй, сонирхлын зөрчилтэй болох нь ойлгогдохоор баримт тендерийн материалд хавсаргасан нь тендерт оролцогчдоос ирүүлсэн материалыг муу хянаж байгаатай холбоотой байна.
- Худалдан авалтын төлөвлөгөөнд бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн үнийн судалгааг муу хийснээр Цахилгаан үүсгэвэр дизель генератор /АДГУ-ҮОВ-КВ/ нийлүүлэх ЦДҮС-2016/ХА-18 дугаартай тендерийн дагуу худалдан авалтын саналыг 3 компаниас авсан боловч шаардлага хангахгүй гэх үндэслэлээр бүгдээс нь татгалзсан, гэвч эхний шалгаруулалтаас хасагдсан "Глим" ХХК-ийн захиралтай ярилцан шууд худалдан авалтаар гэрээ байгуулан авсан байна.
- Металлын гадаргуугийн будаг нийлүүлэх ЦДҮС-2016/АН-Х06 гэрээт ажил гүйцэтгэхээр "Хонка лог хоум" ХХК болон "Нью фонт" ХХК-аас үнийн санал ирүүлсэн. Нью фонт ХХК-аас ирүүлсэн үнийн санал /685л*12.8 мянган төгрөг=8,747.4 мянган төгрөг (НӨАТ ороогүй дүн) /үнийн саналаас татгалзсан мөртөө шууд гэрээгээр "Голден трейд" ХХК-иас /685л*25.0=17,125.0 мянган төгрөг/-өөр буюу 8,377.6 мянган төгрөгөөр нэг үйлдвэрийн адил будгийг илүү үнээр худалдаж авсан байна.

В.Эрсдэл:

ТБОНӨХБАҮХАТ хуулийн зүйл, заалт бүрийг ширхэгчлэн мөрдөхгүй байх нь

компанийн үйл ажиллагаанд хортой, сөрөг үр дагавартай, төдийгүй авилгал бий болох нөхцлийг бүрдүүлнэ.

С.Зөвлөмж:

- Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хэрэгцээ, тэдгээрийн төрлөөр компанид байгаа нөөц, үлдэгдэл, төв компани болон салбарт хэрэгжүүлэх Их засвар, ТЗБАХ-ын арга хэмжээнд зарцуулах шаардлага, худалдан авалтын оновчтой хэмжээ зэргийн тооцоо судалгааг их хэмжээтэй, томоохон дүнтэй худалдан авалтын тендерийн материалд хавсаргаж хэвших,
- Тухайн худалдан авалтаас татгалзсан, бусад гишүүдээс зарчмын зөрүүтэй санал илэрхийлсэн бол үнэлгээний хорооны гишүүний санал, үндэслэлийг протоколд тодорхой тусгахгүйгээр шийдвэр гаргахгүй байх,
- Тендерт шалгараагүй оролцогчдод хүргүүлсэн албан бичгийн үндэслэл болгож байгаа хуулийн заалт зарим үед тохирохгүй байгааг анхаарах,

Д.Үйлчлүүлэгчийн хариу:

ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу 2016 оны худалдан авалтын төлөвлөгөөг нарийвчлан гаргаж ТУЗ, ЭХЯ, ТӨБЗГ-аар батлуулсан төлөвлөгөөг үндэслэн худалдан авах ажиллагааг холбогдох хууль журамд нийцүүлэн зохион байгуулж, дээр дурдагдсан зөвлөмжүүдийг мөрдлөг болгон, шинээр гэрээ хийх бүрт анхаарч ажиллана.

А. Ажиглалт:

Бараа материал, сэлбэг худалдан авалтын өртөг, нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоололтой холбоотой дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. Материалын худалдан авалтыг НӨАТ-тэй дүнгээр бүртгэн, өртгийг буруу илэрхийлэх, НӨАТ-ын тайланд давхар тайлагнах, НӨАТ-гүй худалдан авалтаас НӨАТ-ийг салгаж бүртгэх зэргээр НӨАТ-ын тайланг зөрүүлсэн
2. НӨАТ-гүй худалдан авалт хийж төлөгдөх татварыг бууруулах боломжийг алдсан.
3. Суудлын автомашин, түүний эд анги, сэлбэгийг худалдан авахад төлсөн НӨАТ-ыг өртөгт шингээлгүй, татварын буцаалтаар бүртгэсэн зэрэг болно. Дэлгэрэнгүйг дараах хүснэгтэд үзүүлэв. НӨАТ-ыг өртөгт шингээлгүй, татварын буцаалтаар бүртгэсэн зэрэг болно.

Дээрхи зөрчлийн улмаас дараах эрсдэл үүснэ.

1. Сэлбэг, материалын өртөг болон компанийн орлого үр дүн буруу тооцоологдох
2. НӨАТ-ын тайлан буруу тайлагнагдах

В. Эрсдэл:

2016 оны 1 дүгээр сараас НӨАТ-ийн хуульд орсон шинэчлэл, өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэх арга ажиллагаанд хэрэгжүүлээгүй нөхцөлд алдаа, эрсдэлд хүргэх үр дагавартай.

С. Зөвлөмж:

Дээрхи асуудалтай холбогдуулан дараах зүйлсийг зөвлөмж болгож байна.

1. “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль”-ийн 14.1.1-д заасны дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ-ыг хассан дүнгээр бараа, материалын дансанд бүртгэж;
2. “НӨАТ-ын тухай хууль”-ийн 14.6.1-д заасны дагуу суудлын автомашин, түүний эд анги, сэлбэг худалдан авалтанд төлсөн НӨАТ-ыг материалын өртөгт шингээж байх;
3. Ажил гүйлгээг бэлтгэн нийлүүлэгчийн баримтыг үндэслэн зөв дүнгээр бүртгэлд тусгаж байх;

Д. Үйлчлүүлэгчийн хариу:

Зөвлөмжийг хүлээн авч цаашид анхаарч ажиллана.

Асуудал 4 Бараа ажил үйлчилгээний худалдан авалтын төлөвлөгөөг мөрдөж ажиллахгүй байна.

Тэргүүлэх ач холбогдол 4

А. Ажиглалт:

2016.10.10-ны өдрийн бараа ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тодотгол хийж Гүйцэтгэх Захирлын тушаалаар батлуулсан. Гэвч тодотгол хийгдэхээс өмнө нийт 1,269,120.2 мянган төгрөгийн төлөвлөгдөөгүй худалдан авалт хийгдсэн байна. Үүнээс дүгнэхэд худалдан авалтын төлөвлөгөөг дутуу боловсруулж, худалдан авалтаас хойш үнийн дүнг нэгдсэн хүснэгтэд оруулан тодотгол хийж батлуулж байна. Хэрэгжсэн худалдан авалтыг дагаж төлөвлөгөөнд тодотгол хийж байгаа нь компанийн санхүүгийн сахилга бат хангалтгүй, авилгал үүсэх нөхцлийг зориудаар бий болгож байна.

В.Эрсдэл:

Батлагдсан төлөвлөгөөнд ороогүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, зах зээлийн үнээс хэтэрсэн өндөр үнээр худалдан авалт хийх нь компанийг хохироох эрсдэлтэй.

С. Зөвлөмж:

Бараа, ажил, үйлчилгээний оны эхэнд батлагдсан төсөв, төлөвлөгөөнд тодотгол хийхдээ нэгэнт хэрэгжсэн худалдан авалтыг энэ жагсаалтад нэмж оруулахгүйгээр тодотгол хийхээр журамлах,

Жилийн худалдан авалтын төлөвлөгөөг салбар, нэгжээс захиалга авч, бодитой ул үндэслэлтэй боловсруулан батлуулж байх, Харин гэнэтийн зайлшгүй шаардлагатай төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил, арга хэмжээ болон энгийн хэрэгцээний худалдан авалтыг, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулсны дараа хэрэгжүүлж ажиллах шаардлагатай.

Д.Үйлчлүүлэгчийн хариу:

Компанийн зорилтот түвшний төлөвлөгөө болон тодотгосон төлөвлөгөө батлагдсаны дараа Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан мөрдөж ажиллаж байна. 2016 оны хувьд АСЕМ-тай холбоотой төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил нэлээдгүй хийгдсэн тул компанийн ҮТЗ-ийн хурлаар хойшлуулж болох томоохон хэдэн ажлыг хойшлуулан ирэх оны төлөвлөгөөнд тусгуулж оронд нь шаардлагатай ажлуудыг тусгаж тодотгон хэрэгжүүлсэн. ИЗ, ТЗБАХ, ХО-ын анх батлагдсан дүнд өөрчлөлт ороогүй. Цаашид төлөвлөгөөний үндэслэлийг сайжруулахад анхаарч ажиллана.

А. Ажиглалт:

2016 оны 8-р сарын 29-нд ТБС-ын Баруун хараа дэд станцын дээврийн ажлыг гэрээгээр гүйцэтгэсэн Нүүнэт ХХК-тай байгуулсан гэрээ, ажил дүгнэсэн актаар 39,986,288 төгрөг төлөгдөх ёстой. Энэ дүнгээс баталгаат үлдэгдлийн 5 хувь болох 1,999,314 төгрөгийг хасч үлдэх 37,986,974 төгрөгийг шилжүүлэх ёстой байв. Гэтэл энэ дүнгээс 62,489 төгрөг илүү хасч (ямар шалтгаантай талаар тайлбар, тэмдэглэл хийлгүйгээр) 37,230.1 мянган төгрөг шилжүүлсэн байна.

В.Эрсдэл:

Гүйлгээ холбогдох дэмжих, нотлох баримтын дагуу хийгдээгүй нөхцөлд бүртгэл, тайлан алдаатай илэрхийлэгдэх эрсдэлтэй.

С. Зөвлөмж:

Гэрээ, нэхэмжлэл, ажил дүгнэсэн актын дүнгээс зөрүүтэйгээр мөнгө шилжүүлж байгаа нөхцөлд зохих тайлбар, тэмдэглэлийг ойлгомжтой хийх.

Д.Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч цаашид анхаарч ажиллана.

А. Ажиглалт:

2016 онд тендер болон харьцуулалтын аргаар худалдан авалт хийсэн 2016.05.30-ны өдрийн 2016/109 гэрээний дугаартай "220/110/35кВ-ын Эрдэнэт дэд станц, 110/35/10кВ-ын Булган дэд станцын тогтмол гүйлдийн тэжээл шинэчлэх" ажил 410,213.0 мянган төгрөг, 2016.08.03-ны өдрийн 2016/181 гэрээний дугаартай "Төвийн бүсийн барилгын оффисийн дээврийн засварын ажил" 68,984.3 мянган төгрөг, 2016.10.17-ны өдрийн 2016/205 гэрээний дугаартай "Өвлийн ажлын хувцас нийлүүлэх" ажил 44,460.0 мянган төгрөг, 2016.11.17-ны өдрийн 2016/217 гэрээний дугаар "Цахилгаан дамжуулах сүлжээний технологийн удирдлага, хяналт мэдээллийн системийн программын сервер компьютер нийлүүлэх" ажил 25,060.0 мянган төгрөг, 2016.10.17-ны өдрийн 2016/206 гэрээний дугаартай "Өвлийн ажлын гутал нийлүүлэх" ажил 33,065.0 мянган төгрөгийн эдгээр ажлыг шилэн дансанд шивж оруулаагүй байна.

В.Эрсдэл:

Байгууллагын үйл ажиллагаа, ажил үйлчилгээний талаарх мэдээллийг хэрэглэгч нарт алдаатай хүргэх, өндөр өртөг, үнээр хийгдсэн худалдан авалт, бараа, ажил үйлчилгээ бага зардал, санхүүжилтээр хийгдсэн мэтээр төөрөгдүүлэх эрсдэлтэй.

С. Зөвлөмж:

Шилэн дансанд мэдээлэх үүргийг хуулийн 7.1.3-т зааснаар төлбөрийн даалгаварт 1, 2 дугаар гарын үсэг зурсан албан тушаалтан хариуцах ба шилэн дансны тухай хуулийн дагуу хариуцлагатай, мэдлэг, туршлага бүхий ажилтанд хариуцуулж ажиллуулах шаардлагатай.

Д.Үйлчлүүлэгчийн хариу:

2017 оны 01 дүгээр сараас шилэн дансны шивэлт, хяналтын үүргийг тодорхой болгон түүний үр дүнгээр хүлээх хариуцлага, сахилга батын талаар журамлаж, нягтлан бодогчийн ажил үүргийн хуваарьт оруулсан. Зөвлөмжийг цаашид хэрэгжүүлж ажиллана.

А. Ажиглалт:

“Топ Шаглаа” ХХК-ны 2016 оны 2 дугаар сарын 15-наар бичигдсэн зарлагын баримттай 8,017.8 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалыг 2016 оны 5 дугаар сарын 30-нд бараа материалын үндсэн сэлбэг, хэрэгслээр орлогод бүртгэсэн байна.

В.Эрсдэл:

Бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг хүлээн авсан огноогоор нягтлан бодох бүртгэлд тусгаагүй нөхцөлд эзэнгүйдэх, орхигдох, хэрэгцээгүй болох эрсдэлтэй

С. Зөвлөмж:

Аливаа хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээг тухайн аж ахуйн үйл явдал хэрэгжсэн өдрөөр санхүүгийн программд бүртгэж, анхан шатны баримтыг бүрдүүлж байх

Д.Үйлчлүүлэгчийн хариу:

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрнө. Цаашид энэ талаар анхаарч ажиллана.

Асуудал 8 Харилцахын тайланг арилжааны банкны хуулгын гүйлгээ, үлдэгдлийн дүнтэй зөрүүгүй бэлтгэж, санхүүгийн тайланд гүйлгээ, үлдэгдлийн баталгаажуулалт хийж хавсаргаж байх

Тэргүүлэх ач холбогдол 8

А. Ажиглалт:

- Харилцахын тайланг банкны хуулгын гүйлгээтэй тулган шалгахад 126.5 мянган төгрөгөөр зөрүүтэй байсан нь байгууллагын нэрийг гүйцэд бичээгүйгээс банкны хянагч нягтлан бодогч гүйлгээнд оруулаагүй байна.

- Төрийн банкны харилцахын тайлангаар эхний болон эцсийн үлдэгдэл банкны хуулгын дүнтэй тохирч байгаа боловч, ДТ, КТ- гүйлгээний дүн 41,421.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байгааг шалгаж үзэхэд 12-р сарын 26-ны өдөр “Мон Энержи корпораци” ХХК-д шилжүүлсэн мөнгөний дүнгээр зөрүүтэй байна. Шалтгааныг тодруулж үзэхэд банкны 12-р сарын 27-ны шилжүүлэг эргэж орж ирснийг дахин шилжүүлж ДТ, КТ-гүйлгээний 2 талыг энэ дүнгээр цэвэрлэсэн.

В.Эрсдэл:

Тайлант хугацааны эцэс бүрт банкны тохируулгын тайланг хийгээгүйгээс алдаа эрсдэл нэмэгддэг. Арилжааны банкны хуулгын дүнгээр харилцахын тайланг боловсруулаагүй нөхцөлд банкны гүйлгээний тулган баталгаажуулалтын дүн буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй.

С.Зөвлөмж:

Харилцах дансны тайланг арилжааны банкны хуулгын гүйлгээ үлдэгдлийн дүнтэй зөрүүгүй тохируулан бэлтгэж, санхүүгийн тайланд гүйлгээ, үлдэгдлийн баталгаажуулалт хийж хавсаргаж байх

Д.Үйлчлүүлэгчийн хариу:

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрнө. Цаашид энэ талаар анхаарч ажиллана.

ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	/төгрөг/	
Үзүүлэлт	2015.12.31	2016.12.31
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	6 655 814 675,86	8 047 684 426,66
Дансны авлага	1 093 846 639,50	1 674 445 162,92
Татвар, НДШ-ийн авлага	51 295 056,79	2 744 470,31
Бусад авлага	139 920 237,76	311 135 690,73
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал	3 392 279 578,94	3 655 158 282,38
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	795 628 985,44	610 602 113,52
Бусад эргэлтийн хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгийн дүн	12 128 785 174,29	14 301 770 146,52
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	296 966 213 242,30	290 089 939 600,00
Биет бус хөрөнгө	502 536 214,78	442 714 963,51
Биологийн хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1 397 320 050,66	1 318 313 775,80
Дуусаагүй барилга		753 746 568,96
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	298 866 069 507,74	292 604 714 908,27
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	310 994 854 682,03	306 906 485 054,79
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	2 198 458 402,31	978 425,50
Цалингийн өглөг		793 098 732,90
Татварын өглөг	283 453 739,30	87 911 152,45
НДШ-ийн өглөг		494 100,00
Хүүний өглөг		
Банкны богино хугацаат зээл		1 347 917 877,02
Урьдчилж орсон орлого	185 932 060,89	3 058 795,88
Бусад богино хугацаат өр төлбөр	219 670 491,15	346 741 656,28
Богино хугацаат өр төлбөрийн дүн	2 887 514 693,65	2 580 200 740,03
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	21 635 417 195,16	18 835 359 889,46
Бусад урт хугацаат өр төлбөр		
Хойшлогдсон татварын өглөг	155 185 050,00	450 311 032,75
Хойшлогдсон орлого	23 243 846 973,00	22 530 384 715,81
Урт хугацаат өр төлбөрийн дүн	45 034 449 218,16	41 816 055 638,02
Өр төлбөрийн дүн	47 921 963 911,81	44 396 256 378,05
Эзэмшигчдийн өмч ба капитал		
Төрийн өмч	228 017 764 005,22	228 017 764 005,22
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	42 683 415 225,91	42 651 303 717,99
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	10 196 671 750,08	10 196 671 750,08
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(17 824 960 210,99)	(18 355 510 796,55)
Тайлант үеийн	1 155 228 413,78	(223 615 063,07)
Өмнөх үеийн	(18 980 188 624,77)	(18 131 895 733,48)
Эзэмшигчдийн өмч ба капиталын дүн	263 072 890 770,22	262 510 228 676,74
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	310 994 854 682,03	306 906 485 054,79

"ИНТЕР АУДИТ" ХХК

ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

		/төгрөг/
Үзүүлэлт	2015.12.31	2016.12.31
Борлуулалтын орлого /цэвэр/	33 140 292 142,70	38 147 620 331,26
Борл үүл ал ты н өртөг	27 884 687 745,77	34 773 653 062,20
Нийт ашиг /алдагдал/	5 255 604 396,93	3 373 967 269,06
Түрээсийн орлого	4 290 894,90	7 461 258,92
Хүүгийн орлого	221 402 584,95	253 647 280,27
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого		2 570 595 845,14
Борлуулалт, маркетингийн зардал	75 480 836,22	26 082 242,80
Ерөнхий ба удирдлагын зардал	4 124 872 242,93	4 384 807 739,20
Санхүүгийн зардал	270 947 890,33	267 255 421,85
Бусад зардал	328 587 736,35	1 449 407 464,19
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз /гарз/	41 845 352,86	74 088 799,64
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	(21 097,50)	(55 331 937,29)
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/		
Бусад ашиг /алдагдал/	454 135 245,95	
Татварын өмнөх ашиг /алдагдал/	1 177 368 672,26	96 875 647,70
Орлогын татварын зардал	22 140 258,48	320 490 710,77
Татварын дараах ашиг /алдагдал/	1 155 228 413,78	(223 615 063,07)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/		
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	1 155 228 413,78	(223 615 063,07)
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз /гарз/		
Орлогын нийт дүн	1 155 228 413,78	(223 615 063,07)
Нэгж хувьцаанд ногдох үүрэг ашиг /алдагдал/		

"ИНТЕР АУДИТ" ХХК

ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөг/					
Үзүүлэлт	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг(алдагдал)	Нийт дүн
2014 оны 12 сарын 31 ний үлдэгдэл	228 017 764 005,22	42 688 085 988,97	10 198 142 371,14	(18 959 057 613,19)	261 944 934 752,14
Өмнөх үеийн залруулга				(21 131 011,58)	(21 131 011,58)
Залруулсан үлдэгдэл	228 017 764 005,22	42 688 085 988,97	10 198 142 371,14	(18 980 188 624,77)	261 923 803 740,56
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал				1 155 228 413,78	1 155 228 413,78
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт			(1 470 621,06)		(1 470 621,06)
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(4 670 763,06)			(4 670 763,06)
2015 оны 12 сарын 31 ний үлдэгдэл	228 017 764 005,22	42 683 415 225,91	10 196 671 750,08	(17 824 960 210,99)	263 072 890 770,22
Өмнөх үеийн залруулга				(306 935 522,49)	(306 935 522,49)
Залруулсан үлдэгдэл	228 017 764 005,22	42 683 415 225,91	10 196 671 750,08	(18 131 895 733,48)	262 765 955 247,73
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал				(223 615 063,07)	(223 615 063,07)
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт					-
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(32 111 507,92)			(32 111 507,92)
2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	228 017 764 005,22	42 651 303 717,99	10 196 671 750,08	(18 355 510 796,55)	262 510 228 676,74

"ИНТЕР АУДИТ" ХХК

ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөг/

Үзүүлэлт	2015.12.31	2016.12.31
1.Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	71 954 176 587,21	41 297 500 012,33
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	69 046 199 796,22	39 153 409 096,21
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	15 469 434,00	223 118 182,99
Татаас санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	2 892 507 356,99	1 920 972 733,13
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	60 747 226 234,75	37 478 435 894,68
Ажилчдад олгосон мөнгө	14 597 641 604,01	16 881 793 091,07
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	3 936 145 123,60	4 483 673 031,72
Бараа материал худалдан авахад төлсөн	2 009 772 113,20	5 027 836 333,70
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	239 706 434,99	247 371 649,64
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	937 420 929,51	915 396 605,40
Хүүний төлбөрт төлсөн	49 240 008,97	46 141 402,48
Татварын байгууллагад төлсөн	8 632 606 472,31	5 639 728 387,04
Даатгалын байгууллагад төлсөн	66 196 993,50	62 688 423,00
Бусад мөнгөн зарлага	30 278 496 554,66	4 173 806 970,63
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	11 206 950 352,46	3 819 064 117,65
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлог	233 817 521,14	253 647 280,27
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	9 682 408,01	
Хүлээн авсан хүүгийн орлого	221 402 585,13	253 647 280,27
Бусад	2 732 528,00	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлаг	3 352 674 609,02	2 107 378 673,30
Үндсэн хөрөнгө олж, эзэмшихэд төлсөн	2 827 071 245,82	2 011 301 873,30
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	63 542 460,00	94 356 800,00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	100 935 140,20	
Бусад	361 125 763,00	1 720 000,00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр МГ	(3 118 857 087,88)	(1 853 731 393,03)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого	61 408 981,32	157 426 074,95
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		56 367 384,93
Хүү ба урамшууллын орлого		
Холбоотой талаас өгсөн санхүүжилт		
Бусад	61 408 981,32	101 058 690,02
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага	2 290 040 298,05	730 889 048,77
Зээлийн төлөлт	2 263 537 509,15	483 214 323,82
Төлсөн ногдол ашиг		231 045 680,00
Бусад	26 502 788,90	16 629 044,95
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(2 228 631 316,73)	(573 462 973,82)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	5 859 461 947,85	1 391 869 750,80
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	796 352 728,01	6 655 814 675,86
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		6 655 814 675,86
	8 047 684 426,66	

"ИНТЕР АУДИТ" ХХК

ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2016 ОНЫ ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

Д/д	ҮЗҮҮЛЭЛТ	х.н	2015 оны гүйцэтгэл	2016 оны		Харьцуулалт (хэмнэлт +, хэтрэлт -)			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөөтэй		Өнгөрсөн оны мөн үетэй	
						тоо	хувь	тоо	хувь
1	ЦЭХ-ний дамжуулалтын алдагдал	хувь	3,15	3,30	3,32	0,02		0,17	
2	Дамжуулсан ЦЭХ	сая.Квт.ц	4 611,0	4 789,3	4 722,4	- 66,9	98,6	111,40	102,4
3	Нийт орлого	сая.төг	35 017,3	39 421,2	41 080,4	1 659,2	104,2	6 063,10	117,3
	Дамжуулалтын үйлчилгээний төлбөр	сая.төг	33 140,3	38 201,7	38 147,6	- 54,1	99,9	5 007,30	115,1
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	сая.төг	1 877,0	1 219,5	2 932,8	1 713,3	240,5	1 055,80	156,2
4	Нийт зардал	сая.төг	33 839,9	39 021,2	40 983,5	1 962,3	105,0	7 143,60	121,1
5	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	сая.төг	1 177,4	400,0	96,9	- 303,1	24,2	- 1 080,50	8,2
6	Орлогын албан татварт	сая.төг	22,1	-	320,5	320,5		298,40	
7	Татварын дараах ашиг, алдагдал	сая.төг	1 155,3	400,0	- 223,6	- 623,6	- 55,9	- 1 378,90	- 19,4
8	Борлуулалтын 1 төг-т ногдох зардал	төг	0,97	1,00	1,00	-	100,0	0,03	103,1
9	ХО, ИЗ, ТЗБАХ-ний зардал	сая.төг	3 395,6	6 700,2	6 384,0	- 316,2	95,3	2 988,40	188,0
10	Нийт авлага	сая.төг	2 682,4	2 682,4	3 306,6	624,2	123,3	624,20	123,3
	Богино хугацаат авлага	сая.төг	1 285,1	1 285,1	1 988,3	703,2	154,7	703,20	154,7
11	Бусад авлага	сая.төг	1 397,3	1 397,3	1 318,3	- 79,0	94,3	- 79,00	94,3
12	Нийт өр төлбөр	сая.төг	24 678,1	24 678,1	21 865,9	- 2 812,2	88,6	- 2 812,20	88,6
	Богино хугацаат өр	сая.төг	2 887,5	2 887,5	2 580,2	- 307,3	89,4	- 307,30	89,4
13	Урт хугацаат өр	сая.төг	21 790,6	21 790,6	19 285,7	- 2 504,9	88,5	- 2 504,90	88,5
14	Байгаль орчин инновацийн асуудлыг шийдсэн байдал	тоо		2,0	2,0	-		2,00	
15	Ажиллагсдын тоо	хүн/тоо	1 053,0	1 125,0	1 086,0	- 39,0	96,5	33,00	103,1
16	Цалингийн сан	сая.төг	16 581,8	18 783,3	19 751,9	968,6	105,2	3 170,1	119,1